



## НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

### Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг өөрчлөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/752 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу Стратеги төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй өөрчлөн зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: С.Оюунцэцэг /Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Гишүүд: Н.Амарбаяр /Худалдан авах ажиллагааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Г.Мөнхнасан /Хуулийн хэлтсийн дарга/

С.Рэнцэнмаа /Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/

Г.Янжинлхам /Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн/

Э.Дөлгөөн /Хуулийн хэлтсийн мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга: Д.Жаргалмаа /Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн/

2. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор дуусгаж, Удирдлагын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг /С.Оюунцэцэг/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2018 оны 01 сарын 25-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГҮНДСАМБУУ

1'40500328